

**Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны
ажлын дэд хэсгийн 2016 оны 05 дугаар сарын 23-ны
өдрийн хуралдааны тойм**

Тус Байнгын хорооны 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор байгуулагдсан Киноны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн хуралдаан 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 14.30 цагт Төрийн ордны “Б” танхимд болов.

Байнгын хорооны ажлын дэд хэсгийн хуралдааныг ажлын дэд хэсгийн ахлагч, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн удирдаж, тус Байнгын хорооны зөвлөх Р.Болормаа, референт А.Болортуяа, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёлын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Гантөмөр, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёлын бодлого зохицуулалтын газрын кино, циркийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Ичинноров, Гадаад хэргийн яамны Гадаад сурталчилгаа, мэдээллийн газрын дэд захирал Я.Ариунболд, Гадаад хэргийн яамны Олон улсын эрх зүйн газрын II дугаар нарийн бичгийн дарга Ж.Соёлмаа, Киноны эдийн засагч, Удирдлагын академийн багш, доктор Г.Энхбаяр, Кино судлаач, кино продюсер Б.Түмэн-Өлзий, Соёмбо кино театрын захирал, Монголын кино урлагийн зөвлөлийн тэргүүн Д.Нямдорж, Палентологи археологийн музейн шинэчлэл төслийн ажилтан, хуульч С.Мөнхөөлэй “DOZ энтертайнмент” студийн продюсер А.Мөнгөнзул нар оролцлоо.

Ажлын дэд хэсгийн гишүүд Киноны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй болон найруулгын чанартай саналын томъёоллыг нэгбүрчлэн хэлэлцсэн бөгөөд уг саналын томъёоллоо Байнгын хорооны ажлын хэсгийн гишүүдэд танилцуулахаар болов.

Ажлын дэд хэсгийн хуралдаан 18.20 цагт өндөрлөв.

**Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны
байнгын хорооны Ажлын алба**